

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТАМГЫН ДАРГА

БАТЛАВ.



Ц.ГАНБОЛД

Огноо: 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

“УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ”-Т ХИЙХ ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ХҮРЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙГ
ХОЛБОГДОХ ХУУЛЬ, НОРМ БА ДҮРЭМ, ТӨСВИЙН ҮНЭ БҮРДЭЛ, ТӨСӨВ ЗОХИОХ
ДҮРМИЙН ДАГУУ МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛЖ БУЙ ЭСЭХЭД ДҮГНЭЛТ
ГАРГАХ ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
БАРИМТ БИЧИГ

Шинжээч сонгох урилгын дугаар: № 03-05

Гэрээний дугаар:

УЛААНБААТАР ХОТ

2021 он

03-03 24100 7121111

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.ТЭНГИС

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХОЁРДУГААР ХАВСРАЛТАД XIV.1.1.12, XIV.1.1.18, XIV.1.1.23 ДУГААРТАЙ
БАТЛАГДСАН ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙГ
ХОЛБОГДОХ ХУУЛЬ, НОРМ БА ДҮРЭМ, ТӨСВИЙН ҮНЭ БҮРДЭЛ, ТӨСӨВ ЗОХИОХ
ДҮРМИЙН ДАГУУ МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛСАН ЭСЭХЭД ДҮГНЭЛТ ГАРГАХ
ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2021 оны 03 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 945-10/
21-013

Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛГО “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн зарим зам, гүүрийн барилга, байгууламжийн зураг төслийг Монгол Улсын хууль тогтоомж, норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэхийг нягтлан шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, мэргэжлийн тусалцаа үзүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

Нэг. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолыг үндэслэн “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийн багийг аудитад татан оролцуулах шаардлагатай байна.

Хоёр. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Шинжээч нь Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтад XIV.1.1.12, XIV.1.1.18, XIV.1.1.23 дугаартай батлагдсан зам, гүүрийн барилга, байгууламжийн зураг төслийг Монгол Улсын хууль тогтоомж, норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэхийг нягтлан шалгаж, тооцоололд мэргэжлийн дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулах ажлыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.1. Зам, гүүрийн барилга, байгууламжийн зургийг хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, нормативын дагуу магадлалаар баталгаажуулсан эсэхэд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулах;
- 2.2. Зам, гүүрийн барилга, байгууламжийн төсвийг батлагдсан зургийн дагуу Монгол Улсын хууль тогтоомж, норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэхэд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулах.

Гурав. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтад XIV.1.1.12, XIV.1.1.18, XIV.1.1.23 дугаартай батлагдсан зам, гүүрийн барилга, байгууламжийн зураг төслийг баталгаажуулсан экспертийн тооцоололд хяналт хийж, зураг төсөлд магадлал хийх эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэнэ. Төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулав.

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг, сая төгрөг
XIV.1.1.12	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, дугуйн зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/	2019	2021	10,900.0
XIV.1.1.18	Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 50 км /Хэнтий, Бор-Өндөр сум/	2019	2021	49,368.2
XIV.1.1.23	Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай/	2019	2021	69,000.0

Дөрөв. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь ажлын даалгаварт тусгагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг тусгасан шинжээчийн тайлан бичнэ.

Шинжээчийн тайланд судалгааны явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний талаар зөвлөмж, саналыг боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

Тав. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба Аудитын гуравдугаар газрын "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т гүйцэтгэлийн аудит хийж байгаа багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг авч ажиллана.

Ажлын даалгаварт тусгагдсан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээд нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Аудитын гуравдугаар газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх үе шатны ажлын явцад илэрсэн зөрчил, дангаар шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тухай бүр захиалагч талын холбогдох албанд тушаалтанд шууд мэдэгдэнэ.

Зургаа. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Шинжээч нь аудитын талбарын үе шатнаас эхлэн тайлагналын үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

Эхлэх хугацаа: 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр

Дуусах хугацаа: 2021 оны 5 дугаар сарын 01-ний өдөр

Долоо. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчээр ажиллах иргэн, хуулийн этгээд нь (түншлэлээр оролцож болно) дараах шаардлагыг хангасан боловсон хүчинтэй байна. Үүнд:

- Зам, гүүрийн инженер, инженер-эдийн засагчийн мэргэжлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, тэргүүлэх төсөвчин байх;
- Шинжээч нь мэргэжлээрээ тухайн салбарт 10-аас дээш жил ажилласан туршлагатай байх,
- Зам, гүүрийн барилга, байгууламжийн салбарын норм, норматив, стандарт, эрх зүйн орчны талаар судалгаа хийсэн, барилгын зураг төсөл, төсөвт өртгийн тооцоололд дүгнэлт гаргасан туршлагатай байх.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Найм. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнг захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

Хянасан:

ГУРАВДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЭНХБОЛД


Б.САРУУЛ

Н.АНХБАЯР

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



2019/19 1605

Б.БАТДЭЛГЭР

М.САНГИЖАНЦАН

БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

- МАЯГТ 1-САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
- МАЯГТ 2-ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
- МАЯГТ 3-ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 4-САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ ХҮСНЭГТ
- МАЯГТ 5-АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- МАЯГТ 6-БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 8-ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 9-ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 10-ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (СӨХ)

№	Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: [Үндэсний аудитын газар 15160. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.
2	Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж: Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба Аудитын гуравдугаар газрын “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж байгаа багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг авч ажиллана.
3	Шинжээчийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай: “тийм” эсвэл “үгүй” [үгүй]
4	Санал хүлээн авах хугацаанаас 2 хоногийн өмнө албан бичгээр ирсэн тодруулгад хариу өгнө. [Үндэсний аудитын газрын Захиргаа, удирдлагын газар. Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш tseend-ayushn@audit.gov.mn . Ажлын утас 263533. Гар утас: 88051068]
5	Саналыг Монгол хэлээр ирүүлнэ.
6	Хураангуй жагсаалтад орсон шинжээч эсхүл хуулийн этгээд мөн жагсаалтад орсон бусад компанитай хамтран ажиллаж болно: /хамааралгүй/
7	Шинжээчийн үйлчилгээг гүйцэтгэхэд хуанлийн 35 хоногийн мэргэжлийн үйлчилгээ шаардагдана.
8	Гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг: Дээд хязгаар 10 000 000 /арван сая төгрөг/ байна.
9	Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт , зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүнг илэрхийлсэн хөтөлбөр-аргачлал бүхий менежментийн төлөвлөгөө боловсруулан ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд: Хуулийн этгээд бол: - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /холбогдох тусгай зөвшөөрөлтэй бол/; - Татварын өргүй тухай тодорхойлолт /цахимаас авсан/ ; - Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт /цахимаас авсан/; - Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт; - Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл Сүүлийн 3 жилээр /2018,2019,2020 он/ нотлох баримтын хамт ирүүлэх; - Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар; - Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/; - Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2019, 2020 оны жилийн эцсийн/.

	Хувь хүн/баг бол: - Иргэний үнэмлэхийн хуулбар; - Анкет /CV/; - Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар; - Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/нотлох баримт ирүүлэх; - Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ. /Холбогдох тодорхойлолт нь тухайн сонгон шалгаруулалтыг зарласан цаг хугацаанд хамааралтай байна/ Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага: - Зам, гүүрийн инженер, инженер-эдийн засагчийн мэргэжлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, тэргүүлэх төсөвчин байх; - Шинжээч нь мэргэжлээрээ тухайн салбарт 10-аас дээш жил ажилласан туршлагатай байх, - Зам, гүүрийн барилга, байгууламжийн салбарын норм, норматив, стандарт, эрх зүйн орчны талаар судалгаа хийсэн, барилгын зураг төсөл, төсөвт өртгийн тооцоололд дүгнэлт гаргасан туршлагатай байх.
10	Шинжээчийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг Монгол хэлээр бэлтгэнэ.
11	Ажлын даалгаварт заасан бусад нэмэлт шаардлага Нууцлал: Шинжээч нь ажлын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана. Ажлын даалгаварт тусгагдсан бусад
12	Татвар [Холбогдох татвар, төлбөр хураамж нь санал болгосон үнэд багтсан байна]:
13	Санал ирүүлэх тоо: эх хувь 1 /цаасаар/ мөн цахим PDF файлаар ирүүлнэ.
14	Санал ирүүлэх хаяг: <i>Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068</i>] Гаднах дугтуйд бичих мэдээлэл: Үндэсний аудитын газар.15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр. 04 дүгээр давхар 409 тоот Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Н.Цэнд-Аюуш. <i>Ажлын утас 263533.</i>
15	Саналыг 2021 оны 05-р сарын 04-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө ирүүлсэн байна.

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г _____ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна.

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

Холбоо барих утас: _____

ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1. Ерөнхий танилцуулга

.....

 (Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд/баг/хувь хүн дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. Мөн нотлох баримт ирүүлэх.

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____

Байгууллагын нэр: _____

Мэргэжилтний нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ¹

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

¹ Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.

I. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

1.1 Нэр томъёоны тайлбар	Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ. (б) “Гүйцэтгэгч” гэж захиалагч, шалгагдагч этгээдтэй байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ. (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ. (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ. (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ. (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ. (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ. (ё) “Гишүүн” гэж түншлэл/консорциум/холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ. /Хэрэв байгаа бол/ (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Гүйцэтгэгчийн аль нэгийг, харин “Талууд” гэж оролцогчдыг нь хэлнэ. (з) “Нөхөн төлөх зардал” гэж Гүйцэтгэгчийн ажлын хөлснөөс бусад үйл ажиллагаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ. (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ. (м) “Үйлчилгээ” гэж Ажлын даалгаварт тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ. (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. (ө) “Ажиллах хүчин” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Гүйцэтгэгчийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.
1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль	Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.
1.3 Гэрээнд ашиглах хэл	Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
1.4 Мэдэгдэл	Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.

- | | | |
|-----|--|--|
| 1.5 | Байршил | Үйлчилгээг ажлын даалгаварт заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харьяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой. |
| 1.6 | Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ | Гүйцэтгэгч нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно. |
| 1.7 | Итгэмжлэгдсэн төлөөлөгч | Гэрээний дагуу захиалагч эсхүл Гүйцэтгэгчийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ. |
| 1.8 | Татвар, хураамж | Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой. |
| 1.9 | Авлигал болон залилан мэхлэх үйлдэл | Захиалагчийг төлөөлөн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй төрийн албан хаагч болон сонгон шалгаруулалтад оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч Гүйцэтгэгч бүр сонгон шалгаруулалтад оролцох, гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой. |
- Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй төрийн албан хаагч болон оролцогч шинжээч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

- | | | |
|-----|---------------------------------------|---|
| 2.1 | Гэрээ хүчин төгөлдөр болох | Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ. |
| 2.2 | Үйлчилгээг эхлэх | Гүйцэтгэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой. |
| 2.3 | Гэрээний хугацаа дуусгавар болох | ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш талууд гэрээг дүгнэж дуусгавар болгоно. |
| 2.4 | Гэрээний өөрчлөлт буюу засвар | Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно. |
| 2.5 | Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл | <div style="margin-left: 20px;">2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.</div> <div style="margin-left: 20px;">2.5.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Гүйцэтгэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн</div> |

болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

2.6 Гэрээ цуцлах

- 2.6.1 Захиалагч гэрээг цуцлах
- Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй.
- (а) Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;
 - (б) Гүйцэтгэгч (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;
 - (в) Гүйцэтгэгч нь сонгон шалгаруулалтад оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авлигал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
 - (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Гүйцэтгэгч нь 30-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй болсон;
 - (д) Захиалагч өөрийн санаачилгаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол;
- 2.6.2 Шинжээчийн санаачилгаар гэрээг цуцлах
- Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй
- (а) Захиалагч нь ГЕН-ийн 8 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг Гүйцэтгэгчийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй;
 - (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Гүйцэтгэгч нь 30-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;

3. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 Ерөнхий зүйл

3.1.1 Гүйцэтгэлийн чанар

Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материалын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.

Гүйцэтгэгч нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн Гүйцэтгэгчийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

Төрийн аудитын болон шалгадагч этгээд байгууллага, түүний ажилтнуудтай харьцах ёс зүйг чанд мөрдөж ажиллах, тэдгээрийн нэр хүндэд халдахгүй байх үүрэгтэй.

Төрийн аудитын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг нь гэрээгээр ажил гүйцэтгэж буй

- шинжээч аудитын хуулийн этгээд болон түүний ажилтнуудад нэгэн адил үйлчилнэ.
- 3.2 Ашиг сонирхлын зөрчил Гүйцэтгэгч нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.
- 3.3 Нууцлал Гүйцэтгэгч, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа мэдээллийг аливаа этгээдэд дамжуулах, үйлчилгээний үр дүн, түүнд хамаарах аливаа баримт, тайлан мэдээг нийтэд нээлттэй болгох эрхгүй бөгөөд хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
- 3.4 Гүйцэтгэгчийн хариуцах даатгал Гүйцэтгэгч нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзлын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.
- 3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа Гүйцэтгэгч нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:
- (а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,
 - (б) Гүйцэтгэх ажилд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.
 - (в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа
- 3.6 Тайлагнах хуваарь Гүйцэтгэгч нь тайлан гаргах хуваарьт заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.
- 3.7 Шинжээчийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж Гүйцэтгэгчийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ.
- 3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит цэтгэгч нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖИЛТНУУД

- 4.1 Ажиллах хүчний тодорхойлолт Гүйцэтгэгчийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарьт тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтад багтаана.
- 4.2 Ажилтныг халах буюу солих
- (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Гүйцэтгэгчийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэнэ.
 - (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр

гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрөхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.

- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсэж болох ямар нэгэн нэмэлт зардлыг гүйцэтгэгч нэхэмжлэх эрхгүй болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН БОЛОН ШАЛГАГДАГЧ ЭТГЭЭДИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- | | | |
|-----|---|--|
| 5.1 | Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох | Захиалагч нь ГТН-д заасан шинжээчид үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг олгуулахын тулд шаардлагатай арга хэмжээг авч ажиллана. |
| 5.2 | Гэрээнд хэрэглэх хуульд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт | Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуульд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Гүйцэтгэгчийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой. |

6. ГҮЙЦЭТГЭГЧИД ТӨЛӨХ ТӨЛБӨР

- | | | |
|-----|-----------------------------|--|
| 6.1 | Нийт төлбөр | Гүйцэтгэгчид төлөх нийт төлбөрийн хэмжээ нь ажлын даалгаварт тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчилснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно. |
| 6.2 | Гэрээний үнэ | (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
(б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно. |
| 6.3 | Нэмэлт үйлчилгээний төлбөр | ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг гаргаж захиалагчаас зөвшөөрөл авна. |
| 6.4 | Төлбөр хийх нөхцөл, хуваарь | Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан Гүйцэтгэгчийн дансанд хийнэ.

ГТН-д заасан нөхцөл болзлыг хангасны дараа, Гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой. |

7. ШУДАРГА БАЙДАЛ

- | | | |
|-----|----------------|--|
| 7.1 | Шударга байдал | Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биений эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгын хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна. |
|-----|----------------|--|

8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- | | | |
|-----|---------------------------------|--|
| 8.1 | Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх | Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтад ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө.
Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. |
| 8.2 | Маргааныг шийдвэрлэх | Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй. |

9. БУСАД

9.1 Үйлчилгээ
үзүүлэхтэй
холбоотой
талуудын эрх
үүрэг

Энэхүү гэрээг захиалагч, гүйцэтгэгч, шалгагдагч этгээд гурван тал баталгаажуулж гарын үсэг зурах бөгөөд талууд холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

МАЯГТ 9

II. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчилнө.
{1.1(a)}	Гэрээнд хэрэглэх хууль нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж дүрэм, журам болон стандарт.
1.3	Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.
1.4	<u>Захиалагч:</u> Үндэсний Аудитын газар Захиалагчийн хаяг: Үндэсний Аудитын газар 15160. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Харилцах хүн: Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш tsend-ayushn@audit.gov.mn. Ажлын утас 263533. Гар утас: 88051068] <u>Гүйцэтгэгч:</u> Харилцах хүн: /нөхөх/ Факс: /нөхөх/ И-мэйл: /нөхөх/
{1.6}	{Төлөөлөх эрх бүхий этгээд[нэрийг оруул]/Захирлын нэр, шууд захирагчийн нэр/ <u>Тэмдэглэл:</u> Гүйцэтгэгч нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд ГТН-ийн 1.5-д байгаа хаягийг энд оруулна. Гүйцэтгэгч дангаар оролцож байгаа бол ГТН-ийн энэ зүйлийг бүхэлд нь хасна.
1.7	<u>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:</u> Захиалагчийн : Аудитын гуравдугаар газрын Аудитын менежер Д.Саруул, Ахлах аудитор Б.Батдэлгэр. Ажлын утас: 261805, 261675 /гар утас: 99080337, 99055165/
1.8	Гүйцэтгэгч нь хууль журмын дагуу татвар, төлбөр, хураамжийг өөрөө хариуцна.
{2.1}	Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: Гэрээнд оролцогч талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

2.2	Үйлчилгээ эхлэх хугацаа: <i>Гэрээ байгуулсан өдрөөс гүйцэтгэгч ажлыг эхэлсэнд тооцно.</i>
2.3	Гэрээний дуусгавар болох хугацаа: Гэрээ байгуулагдсанаас хойш хуанлийн 35 хоногийн хугацааг хамарна.
3.4	Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь: Гэрээний туршид Мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байна.
{3.5 (в)}	{Бусад үйл ажиллагаа : <i>Захиалагч гүйцэтгэсэн ажилд чанарын хяналт хэрэгжүүлнэ.</i> }
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <i>Нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний үнэ байна. Гэрээний үнэд тохируулга хийж болохгүй.</i>
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхийн байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал, нэр)

(Албан тушаал, нэр)

(Тамга)

(Тамга)

[АЖЛЫН НЭР]-Д ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭ

Дугаар № _____

хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас _____ регистрийн дугаартай [гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны ____ сарын ____-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав. Үүнд:

1. Үйлчилгээ
 - 1.1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох “Ажлын даалгавар”-т заасан ажил үйлчилгээг (цаашид “ажил” гэх) гүйцэтгэх үүрэгтэй.
 - 1.2. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэхдээ “Гүйцэтгэгчийн ажиллах хүчний жагсаалт”-д заасан мэргэжилтнүүдийг ажиллуулах үүрэгтэй.
 - 1.3. Гүйцэтгэгч нь ажлын даалгаврын хавсралт дахь “Тайлан (дүгнэлт) гаргах хуваарь”-т заасан хугацаанд тайлан (дүгнэлт) гаргаж захиалагчид ирүүлнэ.
 - 1.4. Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд² заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээх бөгөөд сонгон шалгаруулалтад оролцсон баримт бичиг, ажлын даалгавар, ажиллах хүчний жагсаалт, гүйцэтгэгчийн тайлан гаргах хуваарь зэрэг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
2. Хугацаа
 - 2.1. Гүйцэтгэгч нь ажлыг [эхлэх өдрийг бичнэ]-нээс [дуусах хугацааг бичнэ]-ий хооронд, эсхүл талуудын бичгээр харилцан тохиролцсон хугацаанд гүйцэтгэнэ.
3. Төлбөр
 - 3.1. Төлбөрийн дээд хэмжээ.
Захиалагч нь гүйцэтгэгчид гүйцэтгэсэн ажлын төлбөрт төлөх дээд хэмжээ нь [дүн, валютыг бичнэ] болно. Энэ дүнд гүйцэтгэгчийн бүх зардал, ашиг, мөн түүнчлэн гүйцэтгэгчид ногдож болох аливаа татвар, хураамж орсон болно.
 - 3.2. Төлбөрийн хуваарь.
Төлбөрийг доорх хуваарийн дагуу хийнэ:

² Санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг жишиг болгон ашиглана.

- а) Гүйцэтгэгчийн гарын үсэг зурсан гэрээний хувийг захиалагч хүлээн авсны дараа төлөх дүн: *[төлбөрийн 30 хүртэл хувь, дүн, валютыг заах]*;
 - б) Хүлээн зөвшөөрөхүйц тайлан (дүгнэлт)-ийн төслийг захиалагч хүлээн авсны дараа төлөх дүн: *[төлбөрийн 30 хүртэл хувь, дүн, валютыг заах]*;
 - в) Хүлээн зөвшөөрөхүйц эцсийн тайлан (дүгнэлт)-ийг захиалагч хүлээн авсны дараа төлөх дүн: *[төлбөрийн 40 хүртэл хувь, дүн, валютыг заах]*;
- Нийт төлөх дүн: *[төлбөрийн дүн, валютыг заах]*.

3.3. Төлбөрийн нөхцөл.

Төлбөрийг 4 дүгээр зүйлд заасан төлбөрийн нэхэмжлэхийн хувийг захиалагчийн төлөөлөгчид ирүүлснээс хойш 30 хоногийн дотор *[валютыг заах]*-өөр хийнэ.

- 3.4. Энэхүү гэрээний 3.2-ын б, в-д заасан тайлан (дүгнэлт) “Хангалттай” гэж үнэлэгдсэн тохиолдолд тухайн үе шатны ажлын төлбөрийг бүрэн, “Хангалтгүй”, “Сайжруулах шаардлагатай” гэж үнэлэгдсэн тохиолдолд гүйцэтгэлийн үнэлгээний хувийг үндэслэн төлбөрийг тооцож олгоно.

4. Удирдлага

4.1. Ажилд хяналт тавих эрх бүхий этгээд.

Захиалагч нь *[албан тушаал, нэрийг бич]*-ийг ажилд хяналт тавих эрх бүхий этгээдээр томилж байгаа бөгөөд энэхүү этгээд нь гэрээний дагуу хийгдэх үйл ажиллагааг зохицуулах, төлбөрийн нэхэмжлэх, тайлан болон бусад бичиг баримт, эд зүйлсийг хүлээн авч батлах үүргийг хүлээнэ.

4.2. Тайлан

Гүйцэтгэгч нь “Тайлан (дүгнэлт) гаргах хуваарь”-т заасан тайланг хуваарийн дагуу ирүүлэх бөгөөд энэ нь 3 дугаар зүйлийн дагуу төлбөр хийх үндэслэл болно.

5. Гүйцэтгэлийн чанар

- 5.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээг мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд үнэнч шударгаар үзүүлнэ. Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэгчийн ажиллуулж буй аливаа ажилтан шаардлага хангаагүй гэж захиалагч үзсэн бол гүйцэтгэгч уг ажилтныг нэн даруй солино.

6. Нууцлал

- 6.1. Гүйцэтгэгч нь гэрээний хэрэгжилтийн явцад, мөн түүнийг дуусгавар болсноос хойш хоёр жилийн дотор гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил болон энэ гэрээтэй холбоотой өмчлөлийн болон нууцлах шаардлагатай мэдээллийг, эсхүл захиалагчийн үйл ажиллагааны талаар захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүй задруулах эрхгүй.
- 6.2. Бүрэн эцэслээгүй тайлан, дүгнэлтийг бусдад танилцуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.
- 6.3. Нууц мэдээллийг зохих зөвшөөрөлгүй задруулсан буюу ашигласан бол хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

7. Өмчлөл

- 7.1. Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж гүйцэтгэгчийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэнэ.

- | | |
|---|---|
| 8. Гүйцэтгэгч зарим нэг үйл ажиллагаанд оролцохгүй байх | 8.1. Гүйцэтгэгч, түүний нэгдмэл сонирхолтой аливаа этгээд нь энэ гэрээний хугацаанд болон гэрээ дуусгавар болсноос хойш энэ үйлчилгээнээс үүсэлтэй, эсхүл түүнтэй нягт холбоотой аливаа төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэ ажил болон түүний үргэлжлэлээс бусад)-ний гүйцэтгэгчээр ажиллах эрхгүй болохыг гүйцэтгэгч хүлээн зөвшөөрч байна. |
| 9. Даатгал, хариуцлага | <p>9.1. Гүйцэтгэгч нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна.</p> <p>9.2. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.</p> <p>9.3. Захиалагч гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.</p> |
| 10. Эрх шилжүүлэлт | 10.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл түүний аливаа хэсгийг туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхгүй. |
| 11. Гэрээнд мөрдөх хууль ба хэл | 11.1. Энэ гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь <i>[хэрэглэх хэлийг бич]</i> хэл байна |
| 12. Маргааныг шийдвэрлэх | 12.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ. |

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(хаяг, утас, факс г.м шаардлагатай бусад мэдээлэл)

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(хаяг, утас, факс г.м шаардлагатай бусад мэдээлэл)